

ИСПАНИ УЛСАД ЯВСАН ТУХАЙ

Б. Чулуун

Испанийн Гадаад Хэргийн Яамны Соёлын газраас зарласан Испани улсын соёлын судалгааны олон улсын уралдаанд шалгарч Мадрид хотноо 2 сар ажиллаад ирлээ. Манай улсаас 5 хүн уралдаанд оролцсон юм. Намайг шалгаруулсныг манай улсын нэг хувийн сургуулийг дэмсэн хэрэг гэж үзэж байна. Ирж очих онгоцны билетны үнэ, тэнд байх хугацааны буудал, хоол, тээврийн зардлыг Испанийн тал даасан.

Мадридад байх хугацаандаа номын сан, музей, соёлын газруудаар орж соёл, боловсролын талын мэргэжилтэнүүдтэй уулзаж ярилцлаа. Мадридад байхдаа “Иберийн соёлын өвөрмөц шинж чанар” гэсэн сэдвээр тайлан бичлээ. Соёл гэдэг үг бол “культурам” гэдэг латин хэлний гаралтай үг юм. “Нийгмийн гишүүний хувьд хүний эзэмшсэн мэдлэг боловсрол, шүтлэг, зан суртахуун, эрх үүрэг, урлаг, зан заншил зэрэг бүхий л дадал зуршлыг соёл буюу иргэншил гэнэ” гэж Е.Б.Тилор тодорхойлсон бөгөөд хүн судлалын судалгааны нэг төрөл юм.

Испани улс нь эртний соёл орны нэг. Испанийн соёлд эхлээд ром, арабын дараа нь Европын болон капиталист ертөнцийн соёл их нөлөөлсөн түүхтэй. Испани, Португали улс оршдог хойгийг дээр үеэс Иберийн хойг гэж нэрлэдэг байсан. Тэр хойг дээр амьдарч байсан хүмүүсийг иберүүд гэж нэрлэдэг байжээ. Иймээс иберийн соёл нь иберчүүдээс гаралтай ажээ. Испанийн иргэний агаарын тээврийн компанийг өнөөдөр Иберия гэж нэрлэсээр байна.

XIX зуунаас эхлээд Испаничууд хөдөөний (мал, газар тариалан) хүнд амьдралаас зугатан хот суурин газар ирж суурьшиж эхэлсэн ба одоо ч гэсэн энэ нүүдэл үргэлжилсээр байна.

¹Б.Чулуун - Испани хэлний “Говь” дээд сургуулийн захирал

Улаан өндөгний баяр, шинэ жил, үндсэн хуулийн өдөр, майн нэгэн зэрэг томоохон баяраар испаничууд гудамжинд гарч хөгжимдөж, бүжиглэж зугаалахаас гадна хөдөө явах, ууланд гарах, далайн эрэгт очиж усанд орж наранд шарах дуртай.

Испани улс түүх, соёлын өв уламжлалаа хамгаалан улам баяжуулан хөгжүүлж иржээ. Мадрид бол эртний түүхт талбай, ордон, уран баримлаар дүүрэн хот. Христосын шашин өргөн дэлгэрсэн хүмүүс нь шүтлэгтэй, олон сүм хийдтэй учир сүм хийдүүд нь соёл, өв уламжлалаа өнөө хүртэл хайрлан хамгаалсаар байна.

Урлаг, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрээрээ дэлхийд нэрд гарсан испанийн жүжигчид, зохиолчид, эрдэмтэд олон бий. Тухайлбал уран зураач Пикассо, Франциско Гоя, Веласкес, зохиолч Сервантес, Асорин Унамуно, хөгжмийн зохиолч Хоакин Родриго, жүжигчин Хосе Исберт, Альберто, Сара Монтиель ... гэх мэт. Хоол хийх талаар Испаничууд дэлхийд дээгүүр ордог ба виноны үйлдвэрлэлээр Франц, Италийн дараа орж байна. Хүн судлалын музейд байгаа XIX зуунд хамаарагдах эмээл, морин тэрэг манайхтай адилхан байгаа юм. Испани улсад харъяалагдаж байх үеийн Филипины “партизан АЕТА” гэдэг зургийн нум сум монголынхтой төстэй харагдсан.

1849-1875 онд амьдарч байсан Агустин хэмээх 2 метр 35 см өндөр хүний араг ясыг үзээд манай өндөр Гонгор санаанд орж байлаа. Хамгийн сонирхолтой нь амьдарч байсан үе, өндрийн хэмжээ нь бараг таарч байгаа юм. Мөн уран зургийн үзэсгэлэнд Франциско Гояагийн зурсан дөрвөн хөлийг нь олсоор уясан хонины зураг манайхтай адил төстэй харагдлаа. Дуу, хөгжим, бүжигт дуртай хөгжиж цэнгэдэгээрээ манай хоёр ард түмэн адилхан юм.

Испанийн соёлын үнэт зүйлийн нэг бол Их сургуулиуд бөгөөд дэлхийд дээгүүр ордог. Жишээлбэл, Саламанка, комплутенсийн их сургуулиуд байна. Өнөөдөр Испанийн их сургуулиудын хаалга бүх хүнд нээлттэй байдаг. Түүнээс гадна амьдралын түвшин доогуур айл өрхийн хүүхэд болон тэргүүний сурлагатан оюутнуудыг тэтгэлгээр сургадаг байна.

Испани улс 39669094 хүнтэй. 350 хувийн их дээд сургуультай, түүний 10 их сургууль. Зөвхөн Мадридэд хувийн бага сургууль 592, хувийн дунд сургууль 230 байна. Их дээд сургуулиудын оюутны сургалтын төлбөрийг улсын, муж улсын үйлдвэр аж ахуйн газрын, хувийн гэж ангилдаг. Нэг жилийн сургалтын төлбөрийн хэмжээ мэргэжлээс шалтгаалан 2-6 сая төгрөгийн хооронд байна.

Испанийн уран зохиолоос монгол хэлнээ 30 гаруй зохиол орчуулагдсан байна. Тухайлбал Сервантесийн “Кихот ноён”, Лопе де Вегагийн “Хонины булаг”, Аларконы “Гурвалжин малгайт”, Гарсия Лоркагийн “Гэрээслэлийн үг” Мигель Эрнандесын “Дайн”, Хуан Панадерын “Үг”, Рафаель Адвертын “Далайг гатална” зэргийг нэрлэж болно.

Манай улсын Дуурь бүжгийн академик театрт “Кихот ноён”, “Хонины булаг” бүжгэн жүжиг, испани бүжгийн цоморлигийг үзэж болно. Испанийн нэрт найруулагч, хөгжим судлаач Альберто Видал манай улсад хоёр жил ажиллаж байна. Энэ хугацаанд хүүхэлдэйн театрт “Зүүдний хатагтай” хэмээх жүжиг тавьж телурик дууны гурван пьез дуу зохиож, монголын хөөмийг судалж байна. Энэ мэтээр манай хоёр орны соёлын харилцаа хөгжиж байна. Испанид байх хугацаанд “Энх тайвны төлөө” Франциска Матеосын нэрэмжит сан миний ажилд их тусалсан бөгөөд сангийн ерөнхийлөгч Балисарио Санчес испанийн нэрт зураач, уран барималч, хүү Иван Санчес Матеос нь испани-монгол, монгол-испани толь зохиочихоод одоо “Монголын нууц товчоо”-г орчуулж байна. Энэ байгууллага нь дэлхийн ард түмнүүдийн соёлыг түгээн дэлгэрүүлэх замаар энх тайваны төлөө тэмцдэг сайн дурын олон нийтийн байгууллага юм. Монгол оронд испани хэл, соёлыг түгээн дэлгэрүүлж байгааг нь өндрөөр үнэлж манай сургуулийг өөрийн байгууллагын алтан медалиар шагналаа.